



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/197

Улаанбаатар хот

Дүүргийн шинэ жилийн
нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах
Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1387 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн шинэ жилийн нэгдсэн арга хэмжээг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсугай.

2. Шинэ жилийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээг иргэд, олон нийтийг хамруулан, чанар үр дүнтэй зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 1 дүгээр сарын 17 ны өдрийн
А/1197 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ШИНЭ ЖИЛИЙН НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн

ахлагч:

Б.Болормаа

Засаг даргын орлогч

Гишүүд:

М.Давааням

Дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын нарийн
бичгийн дарга бөгөөд Ажлын
албаны дарга (зөвшилцсөнөөр)

Л.Санжийжамц

Засаг даргын Тамгын газрын
дарга

Б.Отгонжаргал

Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн дарга

Ц.Мягмарсүрэн

Санхүү, төрийн сангийн хэлтсийн
дарга

Д.Хүрэлбаатар

Тохижилт, худалдаа
үйлчилгээний хэлтсийн дарга

Г.Дагвадорж

Дүүргийн менежер

Н.Нямзав

1 дүгээр хорооны Засаг дарга

Б.Батзориг

2 дугаар хорооны Засаг дарга

Б.Алтанцоож

Соёлын ордны захирал

Т.Лхагвасүрэн

Цагдаагийн хэлтсийн дарга

Б.Цогбадрах

Онцгой байдлын хэлтсийн дарга

Х.Ганбат

Эрүүл мэндийн төвийн дарга

Д.Оюунгэрэл

Хүүхэд, гэр бүлийн хөгжил,
хамгааллын хэлтсийн дарга

Б.Гэрэлмаа

Багахангай Тохижилт ОНӨААТҮГ-
ын захирал

Ч.Батхуяг

Багахангай Гэрэлтүүлэг, ногоон
байгууламж ОНӨААТҮГ-ын
захирал

Нарийн бичиг:

Б.Цогжавхлан

Нийгмийн хөгжлийн хэлтсийн
дарга

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 11 дүгээр сарын 17 ны өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



ШИНЭ ЖИЛИЙН НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага
1	Шинэ жилийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах захирамж, төлөвлөгөөг боловсруулж батлуулах	2024.11.27	ЗДТГ, Соёлын ордон, Хороод
2	Дүүргийн 1, 2 дугаар хороонд "Мөсөн хотхон" байгуулах, гэрлэн чимэглэл хийх	2024.12.15	ЗДТГ Багахангай Тохижилт ОНӨААТҮГ
3	1, 2 дугаар хороонд сүлд мод засах, чимэглэх	2024.11.24	Багахангай Гэрэлтүүлэг ногоон байгууламж ОНӨААТҮГ
4	"Christmas market" үзэсгэлэн худалдааг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах	2024.11.24 2024.12.31	ТХҮХ Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв
5	НҮБ-ын хөрөнгө оруулалтаар хийгдсэн төвлөрсөн ариун цэврийн байгууламжийг ашиглалтад хүлээн авах	2024.11.28	ЗДТГ
6	Дүүргийн шинэ жилийн баярын нэгдсэн арга хэмжээг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах	2024.12.27	ЗДТГ Соёлын ордон
7	2024 онд амжилт гаргасан шилдэг, тэргүүний хүүхдүүдэд Засаг даргын гарын бэлэг гардуулах, онцгой амжилт гаргасан багш сурагчдыг шагнаж урамшуулах	2024.12.27	ЗДТГ
8	Баярын өдрүүдэд нийтийн хэв журмыг сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулах	2024.12.27 2024.12.31	ЗДТГ Цагдаагийн хэлтэс
9	Шинэ жилийн нэгдсэн арга хэмжээний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах	Тухай бүр	ЗДТГ ТЗУХ
10	Орчны цэвэрлэгээ, худалдаа үйлчилгээ, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангаж ажиллах	Тухай бүр	ТХҮХ Хороод Багахангай Тохижилт ОНӨААТҮГ
11	Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, зөвлөмж сэрэмжлүүлэг өгөх	Байнга	ЭМТ, Хороод
12	Хүнс, эрүүл ахуйн аюулгүй байдалд хяналт тавих, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	Байнга	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс

13	"Багахангайн үдэш-2024" баярын нэгдсэн арга хэмжээг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах	2024.12.31	ЗДТГ
14	Ёслолын буудлага зохион байгуулах	2024.12.31	ЗДТГ ОБХ
15	Перотехникийн бодисын хэрэглээнд хяналт тавих болон гамшиг ослоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	Байнга	ОБХ
16	Нар харах ёслол зохион байгуулах	2025.01.01	ЗДТГ НСУГ ААНБ-ууд
17	Тайлан мэдээг нэгтгэх, холбогдох байгууллагад хүргэх	2025.01.05	ЗДТГ Хороод